



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Ханбогд сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2022/166/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Даланзадгад хот

2022 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: [tserenbayars@audit.gov.mn](mailto:tserenbayars@audit.gov.mn)

Аудитын менежер: Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: [khongorzult@audit.gov.mn](mailto:khongorzult@audit.gov.mn)

Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: “Эн Ай Ти Эс аудит” ХХК

Захирал: Ш.Ичинхорлоо

Утас: 77270808 Цахим хаяг: [nitsbalance@gmail.com](mailto:nitsbalance@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	101.7	114.5
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,334.0	2332.2
	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>2,435.7</b>	<b>2,446.7</b>
	Нийт өр төлбөрийн дүн		
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,435.7	2,446.7
	<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>2,435.7</b>	<b>2,446.7</b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,456.4	1154.7
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,109.0	1,143.8
	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>347.4</b>	<b>10.9</b>
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	0
	<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>347.4</b>	<b>10.9</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	803.1	803.1
	Тайлант оны үр дүн	1,632.7	1,643.6
	<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>2,435.8</b>	<b>2,446.7</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	958.5	996.9
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	958.5	995.4
	<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>-</b>	<b>1.5</b>
	<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>		<b>-1.5</b>
	<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	<b>-</b>	<b>0</b>
	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>-</b>	<b>(1.5)</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>			
	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>999.1</b>	<b>939.5</b>
	Урсгал зардал	999.1	939.5
	Хөрөнгийн зардал	-	0



	<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>997.1</b>	<b>936.9</b>
	Улсын төсвөөс санхүүжих	790.7	788.2
	Орон нутгийн төсвөөс	206.4	148.7
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	2.0	2.6

## **Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Өмнөговь аймгийн Ханбогд сумын ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Суралцагчдын эрүүл, аюулгүй орчинд сурч хөгжих боломжийг бүрдүүлж сургалтын хөтөлбөрийн агуулгыг үр дүнтэй эзэмшүүлж багш, эцэг эх, суралцагч, олон нийтийн хамтын ажиллагаа, боловсролын үйлчилгээг шинэ шатанд гаргаж, чанаржуулна” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгын хүрээнд үйл ажиллагааны дараах чиглэлтэй байна. Үүнд:

- Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн үед сургалтын байгууллага бүр хичээл сургалтын тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангах, цахим хичээлийн сан болон идэвхтэй суралцах, суралцагчийн бие даан ажиллах үйлийг дэмжсэн дасгал, даалгаврын сан бүрдүүлж үр дүнтэй ашиглах;
- Багш, ажилтанд стрессээс сэргийлэх сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, ажлын байранд эерэг уур амьсгал бүхий байгууллагын соёл бүрдүүлэх;
- Дижитал технологийг хичээл, сургалтын үйл ажиллагааны үндсэн хэрэгсэл болгон хөгжүүлэх, түүнийг үр дүнтэй ашиглахад багш нарын мэргэжлийн бүлгийн үйл ажиллагааг чиглүүлж багш ажлын байрандаа тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх.

## **Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант онд Өмнөговь аймгийн Ханбогд сумын ерөнхий боловсролын сургууль 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж нийт 25,725.0 мянган төгрөгийг зарцуулжээ.

- Бага ангийн анги танхимын тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулахад Сумын Засаг дарга, Хүүхэд Хамгааллын Хамтарсан багийн Тэргүүн Х.Нэхийт болон ЗДТГ-ын ажилчид “Бага боловсролын шинэчлэлийг үр өгөөжтэй хэрэгжүүлэх, сурагчдын сурч хөгжих орчныг сайжруулах”-д анхаарал тавьж орон нутгийн төсвөөс 9,850.0 мянган төгрөг;
- Цахим сургууль болсонтой холбоотой /google sheet,google meet, google classroom,FB/ групп-д хичээл байршуулах, эцэг эх болон сурагчдад ковид 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх сургалтууд болон ЭЕШ-д бэлтгэх 8 багш, 12 дугаар ангийн 23 сурагчид БСУГ-аас 2 удаа нийт 16 удаагийн сургалтанд хамруулсан;
- Өмнөговь аймгийн ЗДТГ-т “Цахим Өмнөговь” хөтөлбөрийн хүрээнд “Цахим шилжилтийг хүн бүрт” арга хэмжээнд мэдээлэл технологийн багш нар хамрагдсан;
- Үйлдвэрчний эвлэлээс дүрэмт хувцасны үнийн хөнгөлөлт үзүүлсэн 44 багш ажилтанд дүрэмт хувцас 2,025.0 мянган төгрөг;
- Гадна талбай болон хичээлийн Б байрны гадна тал, дээврийн засврын ажлын төсөл боловсруулан хэрэгжүүлэхэд 13,850.0 мянган төгрөг.



Дэлхийн нийтээр Ковид-19 өвчлөлтэй холбоотойгоор БШУЯ-ны сайдын тушаалын дагуу сургалтын үйл ажиллагааг 3, 9, 10, 11, 12 саруудад буюу 5 сар танхимаар болон цахимаар хосолсон хэлбэрээр явуулсан байна.

### Дөрөв. Аудитын гол асуудал

Тайлант онд Өмнөговь аймгийн Ханбогд сумын ерөнхий боловсролын сургуулийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “Дижитал технологийг хичээл, сургалтын үйл ажиллагааны үндсэн хэрэгсэл болгон хөгжүүлэх, түүнийг үр дүнтэй ашиглахад багш нарын мэргэжлийн бүлгийн үйл ажиллагааг чиглүүлж багш ажлын байрандаа тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх” зорилтын хүрээнд 5 арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулж 999,169.9 мянган төгрөгийг төлөвлөж, гүйцэтгэлээр 939,512.1 мянган төгрөг зарцуулж 99.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсөв санхүү эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас бараа материалын дансанд орлогыг бүртгэн авах нэгдсэн чиглэл өгөх, төсвийг бүлэг хооронд шилжүүлэн зориулалт бусаар зарцуулахад тавих хяналт сул байгааг цаашид анхаарах шаардлагатай.

### Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

### Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 263,479.2 мянган төгрөгийн 6 алдаа, зөрчил илэрснээс 164,401.8 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгах 2 албан шаардлага, 39,677.4 мянган төгрөгийн 4 зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

### 7.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Цалингийн зардлаас байрны түрээсийн зардлыг бүлэг хооронд шилжүүлсэн байна	1	7,337.8							1	7,337.8
2	Бараа материалын тайланд орлогыг зөв	1	10,826.3							1	10,826.3



	ангилж, бүртгээгүй байна.										
3	Бараа материалын зардлын эдийн засгийн ангиллыг буруу бүртгэсэн байна.	1	18,098.7							1	18,098.7
4	Зардлыг холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр хооронд шилжүүлсэн	1	3,413.9							1	2,503.9
5	Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгөнд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгө бүртгэлтэй байна.	1	159,047.2					1	159,047.2		
6	Тайлант хугацаанд хийсэн худалдан авалтын төлбөрийн баримтыг цахим төлбөрийн системд и баримт үүсгэгдээгүй	1	5,354.6					1	5,354.6		
7	Shilendans.gov.mn цахим хуудсанд тухай бүр-1, сар бүр-1 мэдээлэл хоцроосон. Мэдээлэлийг үнэн зөв байршуулаагүй. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ тухай бүр байршуулах мэдээллийн орлогыг 59400.0 мянган төгрөгөөр илүү мэдээлсэн үнэн зөв бодитойгоор мэдээлээгүй байна.	1	59,400					1			



8	Өмнөх аудитаар тогтоосон 1 төлбөрийн акт, өгсөн 1 албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан боловч шилэн дансны хэрэгжилтийн талаар өгсөн 1 албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй, тайлант онд давтагдсан байна										
	Нийт дүн	7	263,479.2								